

Үндэсний Хэмжээнд Албадан Нүүлгэлтийг Хойшлуулах Талаар Өгөх Ойлголт

9 дүгээр сарын 1-нд АНУ-ын Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төвөөс Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтаас урьдчилан сэргийлэхийн тулд бүх түрээслэгчдийг албадан нүүлгэх ажиллагааг хойшлуулахыг мэдэгдлээ. Энэхүү тушаал нь 2020 оны 9 сарын 4- өс 2021 оны 3 сарын 31-ыг хүртэл хүчин төгөлдөр байх болно. **Тушаал нь мужийн эсвэл орон нутгийн албадан нүүлгэх хамгаалалтыг өөрчлөх, эсвэл түүнийг хүчингүй болгохгүй бөгөөд түрээслэгчид болон өмгөөлөгчид орон нутгийн, хотын, болон мужийн хатуу хамгаалалтанд үргэлжлүүлэн ажиллах болно.**

Та дараах зүйлийг мэдэж байх шаардлагатай

- Энэхүү тушаалд орон сууц, зөөврийн сууц болон нэг гэр бүлийн байшин багтсан түрээсийн бүх өмчийг хамруулна.
- Хэрэв түрээслэгчид түрээслүүлэгчиддээ Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төвийн мэдэгдлийг хүргүүлсэн бол 2020 оныг дуустал түрээсээ төлөөгүйн улмаас албадан нүүлгэхийг тушаалаар хориглоно (Доорх мэдэгдлийг харна уу).
- Нэгэнт түрээслэгч өөрийн түрээслүүлэгчиддээ мэдэгдлийг илгээсэн бол түрээслүүлэгч нь шүүхийн нэхэмжлэлээр түрээслэгчийг албадан нүүлгэх, түүнийг нүүлгэн гаргахаар дарамтлах, айлган сүрдүүлэх гэх мэт түрээсийн төлбөр төлөөгүйн улмаас 2021 оны 4 дүгээр сар хүртэл ямар нэгэн үйлдэл хийж болохгүй.
- Энэ нь тушаалын хүчинтэй хугацаа дууссаны дараа төлөх байсан түрээсийн төлбөрийг цуцлах буюу зогсоох, эсвэл хуримтлагдсан түрээсийн төлбөрийг цуцлах эсвэл зогсооход ХҮРГЭХГҮЙ.
- Энэхүү тушаалаар шаардлага хангасан түрээслэгчийг түрээсийн төлбөр төлөөгүйгээс бусад (мужийн эсвэл орон нутгийн хуулиар “үндэслэлтэй шалтгаанаар албадан нүүлгэх” тохиолдолд хамгаалалтанд хамруулна гэж заагаагүй үед) дараах тодорхой шалтгаануудаар 4 дүгээр сараас өмнө албадан нүүлгэхийг зөвшөөрнө:
 - Тухайн байранд байхдаа гэмт хэрэгт холбогдох; оршин суугчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлэх; өмч хөрөнгөд хохирол учруулахаар шууд болон ноцтой эрсдэлд оруулах; холбогдох барилга байгууламжийн дүрэм журам, эрүүл мэндийн тогтоол, эсвэл эрүүл мэнд болон аюулгүй байдалтай холбоотой дүрэм журмыг зөрчих, түрээсийн төлбөрийг цаг тухайд нь төлөх эсвэл орон сууцтай холбоотой төлбөрийг (төлбөр, торгууль, хүүний хугацаа хэтрүүлэх, эсвэл

төлөхгүй байх зэрэг багтсан) төлөхөөс бусад дүрэм журмыг зөрчих.

Би шаардлага хангаж байна уу?

Түрээслэгчид дараах тохиолдолд хамгаалалтанд орох шаардлага хангана:

- эрүүл мэндийн зардал, эсвэл орлогогүй болсны улмаас түрээсээ төлөх боломжгүй байгаа
- 2021 онд хувь хүн дангаараа \$99,000, эсвэл гэр бүлээрээ \$198,000-аас бага орлого олно гэж тооцоолж байгаа, эсвэл урамшуулалын тэтгэмжийн чех авсан, эсвэл 2020 оны татварын тайлан гаргах шаардлагагүй байсан
- засгийн газрын боломжит түрээсийг дэмжих сангаас тусламж авахаар мэдүүлэг өгч байсан эсвэл мэдүүлэг өгч байгаа
- хэрэв боломжтой бол төлж чадах төлбөрийн хэмжээнд тохируулан түрээсийг хэсэгчлэн төлөх үүрэгтэйгээ ойлгож байгаа
- хэрэв түрээслэгчдийг албадан нүүлгэвэл орон гэргүй болох, эсвэл хүн амын хөл хөдөлгөөн ихтэй, шаардлага хангахгүй нөхцөлд шилжин суурьших нөхцөл байдалтай байгаа

Дээрх хамгаалалтанд орохын тулд түрээслэгчид -тухайн гэр бүлд амьдарч буй насанд хүрсэн бүх хүмүүс- өөрийн түрээслүүлэгчиддээ хуулийн дагуу үнэн байдлаа мэдүүлж, эрхзүйн хувьд хамгаалалтанд орох шаардлага хангаж байгаа гэдгийг мэдэгдэж гарын үсэг зурсан мэдүүлгийг (Дараагийн хуудаснаас харна уу) өгөх ёстой. Түрээслэгч нь түрээслүүлэгчтэй холбогдох бүх захидал харилцаа болон мэдүүлгийн хуулбарыг хадгална.

Хэрэв таныг албадан нүүлгэх гэж байгаа буюу эсвэл мэдүүлгийн талаар хууль эрх зүйн тусламж хэрэгтэй байгаа бол орон нутгийн хууль эрх зүйн үйлчилгээний байгууллага буюу эсвэл орон нутгийн олон нийтийн зохион байгуулалтын бүлэгтэй холбогдоорой.



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦААШДЫН ТАРХАЛТААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХИЙН
ТУЛД ӨВЧНИЙГ ХЯНАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТӨВӨӨС ТҮРЭЭСЛЭГЧДИЙГ АЛБАДАН
НҮҮЛГЭХ АЖИЛЛАГААГ ТҮР ХОЙШЛУУЛАХ ТУШААЛЫН ДАГУУ БАТЛАН ТАНГАРАГЛАСАН
МЭДҮҮЛЭГ

Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төвийн мэдүүлэгт гарын үсэг зурахын өмнө мэдэгдлийг анхааралтай хянаж үзэх ба шаардлагыг хангаж байгаа эсэхэд эргэлзэж байвал өмгөөлөгчийн зөвөлгөө авна уу.

Түрээслэгчдэд өгөх заавар

Энэхүү мэдүүлэг нь Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цаашдын тархалтаас урьдчилан сэргийлэхийн тулд оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх ажиллагааг түр хугацаагаар зогсоосон (орон сууцны урт хугацааны моргэйжийн зээлийн хураамж багтаагүй) Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төвийн тушаалаар түрээслэгч, хөлслөгч эсвэл түрээсийн үл хөдлөх хөрөнгийн оршин суугчдад зориулагдсан болно. **Та Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төвийн тушаалын дагуу энэхүү мэдэгдлийн хуулбарыг өөрийн түрээслүүлэгч, үл хөдлөх хөрөнгийн менежер, зөөврийн сууцыг өмчлөгч, эсвэл таныг албадан нүүлгэх эрхтэй бусад хүмүүст хүргэх ёстой.** Түрээсийн гэрээ, орон сууцны гэрээнд бичигдсэн насанд хүрсэн хүн бүр энэ мэдүүлгийг бөглөх ёстой. Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төвийн тушаал нь сунгагдаж, өөрчлөгдөж, хугацаа нь дуусаагүй байгаа тохиолдолд 2021 оны 3 сарын 31 хүртэл таныг амьдарч байгаа газраас тань албадан нүүлгэхээс хамгаална. Та түрээсийн төлбөрөө төлөх болон түрээсийн бусад бүх нөхцөл, оршин суугаа газрынхаа дүрмийг дагаж мөрдөх шаардлагатай хэвээр байна. Таныг түрээсийн төлбөр төлөөгүйгээс бусад тодорхой шалтгаанаар албадан нүүлгэх магадлалтай. Энэ нь хэрэв та чухал мэдээллийг төөрөгдүүлэх, нуун дарагдуулах, худал хэлэх гэх мэт үйлдэл гаргавал торгуулах эсвэл яллагдаж, хоригдож болно гэдгийг батлан тангарагласан мэдүүлэг юм. Энэхүү мэдүүлгийн хуулбар эсвэл зургийг баримт болгон хадгална уу.

Албадан нүүлгэх эрхтэй түрээслүүлэгч болон бусад хүмүүст өгөх заавар

Энэхүү мэдүүлгийг хүлээн авсны дараа тушаалд дурдагдсан хүлээн зөвшөөрөгдсөн шалтгаанаас бусад шалтгаанаар “мэдүүлэгчийг орон байрнаас хөөх, эсвэл хөөх ямар нэгэн шалтгаан гаргах” зэрэг “үйлдэл хийх” нь тушаалыг зөрчсөн үйлдэл болно. Үүнд нүүлгэх мэдэгдэл гаргах, шүүхэд албадан нүүлгэх тухай өргөдөл гаргах, эзэмших зөвшөөрөл авах өргөдөл гаргах зэрэг үйлдлүүд хамаарна. Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төвийн энэхүү мэдүүлгийг хавсаргасан тушаалыг зөрчсөн тохиолдолд хэрэв хүний амь насанд хохирол учруулаагүй бол \$100,000 хүртэл торгууль оногдуулах эсвэл нэг жилийн хорих ял оногдуулах, эсвэл энэ 2 шийтгэлийг хоёуланг нь оногдуулах, хэрэв тушаалыг зөрчиж хүний амь насанд хохирол учруулсан бол \$250,000 хүртэл торгууль оногдуулах эсвэл нэг жилийн хорих ял оногдуулах, аль эсвэл энэ 2 шийтгэлийг хоёуланг нь оногдуулах, мөн хуульд өөрөөр зааснаар шийтгэл оногдуулна. Энэхүү тушаалыг зөрчсөн байгууллага хэрэв хүний амь насанд хохирол учруулаагүй бол авсан арга хэмжээ бүрт \$200,000 хүртэл торгууль оногдуулах, эсвэл хүний амь насанд хохирол учруулсан бол авсан арга хэмжээ бүрт \$500,000 хүртэл торгууль оногдуулах буюу мөн хуульд өөрөөр зааснаар шийтгэл оногдуулна. АНУ-ын Хууль зүйн яам нь зохих ёсоор эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр (АНУ-ын Хууль тогтоомжийн 18-р зүйлийн 3559, 3571-р хэсэг, 42-р зүйлийн 271, Холбооны хууль тогтоомжийн 42-р зүйлийн 70.18-р хэсэг) шүүх хуралдааныг эхлүүлж болно.

Би энэхүү баримт бичгийн хуулбарыг өөрийн амьдарч буй үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч болон / эсвэл түрээслэгчид дараахь аргаар дамжуулан өгсөн болохыг баталж байна (Энэ бүх хүсэлтийг шалгана уу):

- | | | |
|---|---------|--------------|
| ☐ Захидал: | _____ | Огноо: _____ |
| ☐ Баталгаат захидал: | _____ | Огноо: _____ |
| Илгээмжийн дугаар: _____ | | |
| ☐ Цахим шуудан: | _____ | Огноо: _____ |
| ☐ Факс: (____) _____ | - _____ | Огноо: _____ |
| ☐ Текст зурвас: (____) _____ | - _____ | Огноо: _____ |
| ☐ Гарт хүргэх (Нэр): | _____ | Огноо: _____ |
| ☐ Бусад (тайлбарлах): | _____ | Огноо: _____ |

ХАМГААЛАЛТАНД ХАМРАГДАХ ТУХАЙ МЭДҮҮЛЭГ

Миний бие АНУ-ын Хууль тогтоомжийн тухай хуулийн 26-р зүйлийн 1746 хэсэгт заасны дагуу дараах мэдүүлэг нь үнэн зөв болохыг үүгээр нотолж байна:

- Би төрөөс авах боломжтой түрээсийн болон орон сууцны бүх тусламж дэмжлэгийг авахын тулд бүхий л боломжоо дайчилсан;
- Би 2021 онд жилийн орлого \$99,000 -ээс хэтрэхгүй гэж тооцоолж байгаа ба (эсвэл хамтарсан татварын буцаан олголтын тайлан өгөхөд \$198,000-аас хэтрэхгүй), АНУ-ын Татварын албанд 2020 оны орлогоо тайлагнах шаардлагагүй байсан, эсвэл АНУ-ын Коронавирусийн тусламж, тэтгэмж, эдийн засгийн аюулгүй байдлын тухай хууль буюу Халамжийн тухай (CARES Act) хуулийн 2201 дэх хэсэгт заасны дагуу эдийн засгийн нөлөөллийн төлбөр (урамшуулалын тэтгэмж чех) -ийг авсан;
- Өрхийн орлого нэлээд хэмжээгээр багассан, ажлын цаг болон цалингийн нөхөн олговор олгохгүй болсон, ажлаас халагдсан, эрүүл мэндийн зардал нэмэгдсэний улмаас түрээсийн төлбөр болон орон сууцны төлбөрийг бүрэн төлөх боломжгүй байгаа;
- Бусад үл хамаарах зардлыг харгалзан үзэж тухайн хүний нөхцөл байдалд тохируулан хүлээн зөвшөөрсөн төлбөрийн ихэнхи хэсгийг цаг тухайд нь төлөхийн тулд хичээх болно;
- Хэрэв намайг албадан нүүлгэвэл би орон гэргүй болж орон гэргүй хүмүүсийн байр руу нүүх, эсвэл өөр сонголт байхгүй тул хоорондоо маш ойрхон амьдардаг бусад хүмүүсийн байранд хамт амьдрах шаардлагатай болж магадгүй юм.
- Би одоо ч түрээсийн төлбөр, эсвэл байрны төлбөрөө төлөх ёстой бөгөөд түрээсийн гэрээ, түүнтэй адилтгах гэрээний дагуу хүлээх бусад үүргээ биелүүлэх ёстой гэдгээ ойлгож байна. Миний түрээсийн гэрээ болон түүнтэй адилтгах гэрээнд заасны дагуу түрээс болон орон сууцны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд төлөх төлбөр, торгууль, хүүг үргэлжлүүлэн тооцож эсвэл хурааж авах боломжтой гэдгийг би ойлгож байна.
- Би албадан нүүлгэлтийг түр хугацаагаар зогсоох тушаалын хугацаа дуусах үед буюу 2021 оны 3-р сарын 31-ний өдөр түрээслүүлэгч энэхүү тушаалын үед болон өмнө нь төлөөгүй байсан төлбөрийг бүрэн төлөхийг шаардах ба төлөөгүй тохиолдолд мужийн болон орон нутгийн хууль, тогтоомжийн дагуу намайг албадан нүүлгэж болзошгүй гэдгийг ойлгож байна.
- Би аливаа худал болон төөрөгдүүлсэн мэдэгдэл гаргах, хайхрамжгүй байдал гаргавал эрүүгийн болон иргэний хэрэг үүсгэж торгох, шийтгэх, хохиролыг төлүүлэх эсвэл хорих ял авах зэрэг ял шийтгэл оногдуулж болзошгүйг ойлгож байна.

Мэдүүлэгчийн гарын үсэг _____ Огноо _____

¹ “Available government assistance” means any governmental rental or housing payment benefits available to the individual or any household member.

² An “extraordinary” medical expense is any unreimbursed medical expense likely to exceed 7.5% of one’s adjusted gross income for the year.

³ “Available housing” means any available, unoccupied residential property, or other space for occupancy in any seasonal or temporary housing, that would not violate Federal, State, or local occupancy standards and that would not result in an overall increase of housing cost to you.

DECLARATION OF ELIGIBILITY

I certify under penalty of perjury, pursuant to 28 U.S.C. 1746, that the foregoing are true and correct:

- I have used best efforts to obtain all available government assistance for rent or housing;¹
- I either expect to earn no more than \$99,000 in annual income for Calendar Year 2021 (or no more than \$198,000 if filing a joint tax return), was not required to report any income in 2020 to the U.S. Internal Revenue Service, or received an Economic Impact Payment (stimulus check) pursuant to Section 2201 of the CARES Act;
- I am unable to pay my full rent or make a full housing payment due to substantial loss of household income, loss of compensable hours of work or wages, lay-offs, or extraordinary out-of-pocket medical expenses;
- I am using best efforts to make timely partial payments that are as close to the full payment as the individual's circumstances may permit, taking into account other nondiscretionary expenses;
- If evicted I would likely become homeless, need to move into a homeless shelter, or need to move into a new residence shared by other people who live in close quarters because I have no other available housing options.³
- I understand that I must still pay rent or make a housing payment, and comply with other obligations that I may have under my tenancy, lease agreement, or similar contract. I further understand that fees, penalties, or interest for not paying rent or making a housing payment on time as required by my tenancy, lease agreement, or similar contract may still be charged or collected.
- I further understand that at the end of this temporary halt on evictions on March 31, 2021, my housing provider may require payment in full for all payments not made prior to and during the temporary halt and failure to pay may make me subject to eviction pursuant to State and local laws.
- I understand that any false or misleading statements or omissions may result in criminal and civil actions for fines, penalties, damages, or imprisonment.

Signature of Declarant _____ Date _____

¹ "Available government assistance" means any governmental rental or housing payment benefits available to the individual or any household member.

² An "extraordinary" medical expense is any unreimbursed medical expense likely to exceed 7.5% of one's adjusted gross income for the year.

³ "Available housing" means any available, unoccupied residential property, or other space for occupancy in any seasonal or temporary housing, that would not violate Federal, State, or local occupancy standards and that would not result in an overall increase of housing cost to you.